

著者(英)	Lkhagvasuren Ichinkhorloogiin
journal or publication title	Senri Ethnological Reports
volume	42
page range	1-225
year	2003-10-25
URL	http://doi.org/10.15021/00001890

Senri Ethnological Reports

42

XX зууны Монголчууд

Зохиож эмхэтгэсэн

И.Лхагвасүрэн

National Museum of Ethnology
Osaka 2003

The National Museum of Ethnology
Senri Expo Park, Suita
Osaka 565-8511, Japan

© 2003 by The National Museum of Ethnology
All rights reserved. Printed in Japan

Publication Data

ISBN 4-901906-16-X C3039 ISSN 1340-6787

Book design by B2 Design, Kyoto, Japan
Typeset by Yubunsha Co., Ltd., Osaka, Japan

Өмнөх үг

И.Лхагвасүрэн

20-р зуун төгсөж, хүн төрлөхтөн 21-р зуунтайгаа золголоо. Улиран одож байгаа 20-р зуун, бидний Монголчуудын хувьд ямар зуун байсан бэ?

Энэ асуултын үнэн зөв хариултыг одоо Монголчууд бид бүгдээрээ хайж байна. Саяхан болтол бид дэлхийн 2 дахь социалист орон хэмээгдэж, хийсэн бүхэн, олсон ололт амжилтуудаараа бахархаж байсан билээ. Гэтэл улс орныхоо хөгжил цэцэглэлт, хүн ардынхаа сайн сайхны төлөө гэсэн чин эрмэлзэл, итгэл үнэмшилтэйгээр хичээнгүйлэн байгуулж байсан социалист нийгэм маань 20-р зууны төгсгөл үе болж ирэхэд цаашид оршин тогтнох чадваргүй гэдэг нь нэгэнт тодорхой болж нуран унасан билээ. Үүнд олон монгол хүн итгэж чадахгүй байсан. Одоо ч энэ байдал үргэлжилсээр байна. Гэсэн ч социализм дэлхийн хэмжээнд нэгэнт их туршилтын гунигт түүх болон үлджээ. Социализмын он, жилүүдэд Монгол орны нүүр царай, нүүдэлчин монголчуудын ахуй амьдралыг өөрчлөхөд хүчтэй нөлөөлсөн олон үйл явдлууд болж өнгөрсөн билээ. Тэдний дундаас дараахь гурван үйл явдлын талаар заавал тогтож ярих ёстой гэж бодож байна. Энэ бол малчин ардын малыг нийгэмчлэх замаар хоршооллын хөдөлгөөнийг өрнүүлж, олон тооны нэгдлүүдийг байгуулсан явдал, атар газрыг эзэмших хөдөлгөөн өрнүүлж, Монгол хүн олон мянган га талбайд тариа, ногоо тариалдаг болсон явдал, орчин үеийн аж үйлдвэрийн салбарыг буй болгож, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ гадаад, дотоодын зах зээл дээр борлуулдаг болсон явдлууд юм.

Энэ бол манай нийгэмийн амьдралд хүчтэй нөлөө үзүүлсэн, томоохон үйл явдлууд байсан билээ. Малыг нэгдэлд төвлөрүүлсэн нь малаас авдаг түүхий эдийг улсын үйлдвэрийн газарт шилжүүлж, үйлдвэрлэл явуулах өргөн боломжийг нээж өгсөн юм. Арьс, шир, ноос, ноолуурыг орчин үеийн үйлдвэрийн аргаар боловсруулж хийсэн бүтээгдэхүүнүүд нь дотоодын болон олон улсын зах зээл дээр гарч эхэлсэн билээ. Монгол орон ингэж түүхэндээ үйлдвэрийн аргаар бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, экспорлодог орон болсон юм.

Хүн амыг хүнсээр хангах, нэгдлийн болон амины малыг тэжээлийн найдвартай баазтай болгох асуудлыг атар газрыг эзэмших замаар бүрэн шийдвэрлэсэн юм. Үр, тариа хүнсний ногоог ихээр тариалах болсон нь дотоодын хүнсний хэрэгцээг хангаад зогсохгүй, ургац сайтай жилүүдэд гадаад экспортонд гаргах боломжтой болсон юм. Монгол орон ингэж түүхэндээ газар тариалангийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг, экспортлодог орон болсон билээ. Малын тэжээлийн үйлдвэрүүдийг

байгуулж, отор-тэжээлийн аж ахуйнуудыг олноор буй болгосон нь малын зүй бусын хорогдлыг багасгах, тоо толгойг нь тогтвортой өсгөхөд үлэмж ач холбогдлоо өгч байлаа.

Энэ бүгд бол социализмын давалгаан доор өөрөө аяндаа буй болчихоогүй, манай ахмад үеийнхний удаан жилийн хичээл зүтгэл, идэвх санаачлага, шаргуу хөдөлмөрийн үр дүнд буй болсон юм. Өнөөдөр дэлхийн социализм нуран унасан тэр нурангин дундаас бид улс орноо сэргээн босгож, хөгжил дэвшлийн замаар авч явахыг хичээж байна. Энд хүн бүрийн хүчин чармайлт, идэвх зүтгэл хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой.

Та бүхэнд толилуулан байгаа энэхүү жижигхэн товхимол бол социалист нийгэм байгуулж байсан тэр жилүүдийн үйл явдалыг дахин нэг тунгаан бодоход чинь уншигч авхай танд туслах зорилготойг минь болгоон соёрхоно уу.

Гарчиг

ӨМНӨХ ҮГ	1
МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР РЕНЧИНГИЙН МИНЖҮҮР	5
МАХН-ЫН ТХ-НЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ САЙД АСАН ПААВАНГИЙН ДАМДИН	105
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН ШАРАВЫН ГУНГААДОРЖ	171
АРДЫН УРАН ЗОХИОЛЧ, ТӨРИЙН ШАГНАЛТ, ЯРУУ НАЙРАГЧ ДЭНДЭВИЙН ПҮРЭВДОРЖ	199
ТӨГСГӨЛИЙН ҮГ	223